



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

Хорооны 2014 оны 467 дугаар тогтоолыг
хүчингүй болгох тухай


Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2015 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаас гарсан зөвлөмж, үнэт цаасны төлбөр, тооцооны байгууллагын бүтцийн өөрчлөлт, банкаар дамжуулан Засгийн газрын өрийн хэрэгсэлд хөрөнгө оруулах сонирхол бүхий хөрөнгө оруулагчдын хүсэлтийг тус тус харгалзан, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1 дэх заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Нэр бүхий арилжааны банкуудын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай” 467 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулж, нэр бүхий арилжааны банкуудад олгосон “харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавараар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил, үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийн үйлчлэх хугацааг 2015 оны 12 дугаар сарын 26-ны өдөр хүртэл байхаар тогтоосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000535